



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

**Дүүргийн шатар сонирхогчдын  
тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойг угтаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатар сонирхогчдын анхдугаар тэмцээнийг 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

2. Тэмцээнд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган дүүрэг орон нутгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байгаа хавсралтад нэр дурьдсан иргэд, албан хаагчдыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнахаар шийдвэрлэсүгэй.

2. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 сарын  
24-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралт



Шагнагдах хүмүүсийн нэрс

| Д/д | Овог нэрс     | Эрхэлсэн ажил, мэргэжил  | Регистрийн дугаар |
|-----|---------------|--|-------------------|
| 1   | Д.Буянхишиг   | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан   | ЙС52031511        |
| 2   | Д.Довчин      | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан   | Ч336031410        |
| 3   | Г.Лхагвасүрэн | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан   | ЗЮ46080362        |
| 4   | Ч.Цэндмаа     | Чингэлтэй дүүргийн 70 дугаар цэцэрлэгийн багш,<br>арга зүйч  | ЧБ62071306        |
| 5   | Д.Жаргал      | Чингэлтэй дүүргийн 70 дугаар цэцэрлэгийн багш  | ХН66052885        |
| 6   | М.Гантуяа     | Чингэлтэй дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн Гэр бүлийн хамгааллын ажилтан                           | РТ86032766        |
| 7   | А.Болормаа    | Чингэлтэй дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан             | ХГ85040100        |
| 8   | Н.Янжинлхам   | Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн ажилтан           | ИФ80090903        |
| 9   | Д.Алтаннавч   | Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Монгол ардын намын бүлгийн ахлах ажилтан                | ХВ77050909        |
| 10  | Б.Батболд     | Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэгийн манаач  | ЧП82100219        |
| 11  | П.Гажидсүрэн  | Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэгийн туслах багш   | ГН71062401        |
| 12  | Б.Лхагваням   | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтсийн Дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн | ТЯ85041730        |
| 13  | Н.Дэлгэрмаа   | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч         | ШГ81051869        |
|     |               | Чингэлтэй дүүргийн Засаг даргын  |                   |

|    |                 |   |             |
|----|-----------------|---|-------------|
| 14 | Б.Энхсайхан     | Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан ажилтан   | ЧМ86052673  |
| 15 | Д.Батзориг      | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн Байгаль, орчин ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн | АЭ87081270  |
| 16 | Т.Оюунтунгалаг  | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтсийн Хөдөө аж ахуй, ахуйн үйлчилгээ хариуцсан ажилтан      | ГП90121846  |
| 17 | Ч.Отгонсүрэн    | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын мэдээлэл аюулгүй байдлын офицер  | АР78092709  |
| 18 | Х.Отгонжаргал   | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч  | АМ82030307  |
| 19 | Х.Цогтуяа       | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн үйлчлэгч   | ДЭ70110909  |
| 20 | С.Амарбаясгалан | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны Засаг дарга   | ХЙ82062178  |
| 21 | Д.Алимаа        | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны Засаг дарга  | ВП77061304  |
| 22 | Н.Дуламсүрэн    | Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны Зохион байгуулагч  | ХГ85080304  |
| 23 | Э.Одончимэг     | Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Зохион байгуулагч   | НЬ85032365  |
| 24 | Б.Дандарбаатар  | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны сахиул  | ГЮ61052306  |
| 25 | Б.Доржбаатар    | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны үйлчлэгч  | ХГ62110304  |
| 26 | Ц.Энхцэцэг      | Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны хэсгийн ахлагч   | ЦД56042805  |
| 27 | Т.Цолмон        | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны хэсгийн ахлагч   | ЖЬ63072660  |
| 28 | Б.Уранчимэг     | Мэргэжлийн өвчин судлалын төвийн сувилагч   | ЧЖ61010462  |
| 29 | Ц.Тунгалагболор | Чингэлтэй дүүргийн 173 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч  | ЦГ65041101  |
| 30 | Д.Цэцэгдэлгэр   | Чингэлтэй Эрүүл мэндийн төвийн бага эмч   | ДЮ 69032207 |
| 31 | Л.Лувсанцэрэн   | "Монгол хонди" ХХК-ийн эдийн засагч   | ДГ87070618  |
| 32 | Ц.Түмэндэмбэрэл | Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтсийн ажилтан  | ОС88040417  |
| 33 | Г.Наранзул      | Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтсийн ажилтан  | ИЮ86060186  |

|    |               |  |            |
|----|---------------|--|------------|
| 34 | Ю.Ичинноров   | Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК-ийн зам талбайн үйлчлэгч | ЧН66011168 |
| 35 | С.Туяа        | "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК-ийн зам талбайн үйлчлэгч          | ЧД63093001 |
| 36 | А.Отгонбаатар | "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК-ийн зам талбайн ачигч             | ХК82112171 |
| 37 | Д.Нэргүй      | "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК-ийн зам талбайн ачигч             | ЙК72013031 |
| 38 | Т.Нэргүй      | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны хэсгийн ахлагч                  | ШЖ61081006 |
| 39 | Д.Сувдаа      | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны ахмад багш                      | УХ53051009 |
| 40 | Т.Алтантуяа   | Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн ахлах багш                  | АМ73120609 |
| 41 | Д.Рагчаа      | Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн эмч                         | УШ47083005 |
| 42 | Г.Алтаннавч   | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Хэсгийн ахлагч                   | НТ81092407 |
| 43 | Д.Болормаа    | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Хэсгийн ахлагч                   | МХ76072702 |
| 44 | Г.Цогзолмаа   | Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Хэсгийн ахлагч                   | ХВ55120709 |
| 45 | Б.Баасансүрэн | Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Хэсгийн ахлагч                   | РФ52062669 |

Төлөвлөсөн: Хуулийн зөвлөх бөгөөд  
хүний нөөц хариуцсан ажилтан



Г.Сэлэнгэ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

**Буцалтгүй тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхны даргаар 1992-1996 онд ажиллаж байсан Дамбадаржаа овогтой Тогтохжаргал нь биеийн эрүүл мэндийн улмаас удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа тул эмчилгээний зардалд туслах зорилгоор Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Шаардагдах зардал 1000000 (нэг сая) төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

**Шагналд уламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

**МОНГОЛ УЛСЫН “АРДЫН ЖҮЖИГЧИН ЦОЛ”-ООР:**

- |                    |  |
|--------------------|--|
| 1. Надмидын Мягмар | Соёл урлагийн их сургуулийн сургуулийн Тайзны ярианы зөвлөх багш |
|--------------------|--|

**МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛ”-ООР:**

- |                        |  |
|------------------------|--|
| 1. Чимэдийн Дагшигдорж | Архитектурын нэгдэл ХХК зөвлөх, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн |
|------------------------|--|

**МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ ТЭЭВЭРЧИН ЦОЛ”-ООР:**

- |                         |  |
|-------------------------|--|
| 1. Бархүүгийн Бахбариад | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан |
|-------------------------|--|

**“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР:**

- |                             |   |
|-----------------------------|---|
| 1. Цэвэлсономын Цэрэнжигмэд | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны ахмад настан                                |
| 2. Аюурзаны Энх-Амгалан     | Бодлого судлалын төвийн тэргүүн   |
| 3. Цэвэгжавын Бат-Эрдэнэ    | “Ханну Арх” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн |
| 4. Солийн Одон              | “СИТИ” дээд сургуулийн багш, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн           |

5. Лувсаншаравын Туяа “Вертикаль” ХХК-ийн Ерөнхий захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн

“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:

1. Лувсангийн Цэвээнсүрэн “Өгөөмөр дэвших” ХХК-ийн зөвлөх
2. Эрдэнэчулууны Нарангэрэл Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургуулийн Ярих урлагийн тэнхимийн Ахлах багш
3. Гүнчээгийн Өлзийбаяр Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын багш
4. Нямбуугийн Оюунчимэг Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан, “Соён гэгээрүүлэгч” телевизийн үзэгчдийн танхимын тэргүүн
5. Сурмаагийн Чойням Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны ахмад настан
6. Гомбосүрэнгийн Цэцгээ Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан
7. Жамъяанжавын Жүгдэр Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан
8. Даваарагийн Сосорбарам Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан
9. Пооворын Сумхүү Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
10. Санжийн Чулуун Төгс тэмүүлэл ХХК-ий Нягтлан бодогч Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
11. Даваадоржийн Хишигсүрэн “АРТ СИТИ” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
12. Ёндонжамцын Батбаяр “Форум Арт” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
13. Сандангийн Түмэн-Өлзий Эрхэт констракшн ХХК-ийн Зөвлөх архитектор, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
14. Очирпүрэвийн Саранцацрал “Өрх” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн
15. Дамдинжавын Долсонжав “Монүз” ЗНБ-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн



- |                                |   |
|--------------------------------|---|
| 16. Галсанцэрэнгийн Нямцогт    | “Сүлд Проект” ХХК-ий захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн                      |
| 17. Должинжавын Эрдэнэбилэг    | “Билгүүн шонхор” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн                  |
| 18. Өлзийбүрэнгийн Ганболд     | “Эдшил” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн                           |
| 19. Данзаншаравын Цэвэлмаа     | Монголын Мянганы сорилтын сангийн Барилгын зөвлөх, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн |
| 20. Ламжавын Чагнаа            | “Автор” ХХК-ийн Архитектор, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн                        |
| 21. Индрээбүдиймаагийн Аюушжав | “Эс энд эй” трейд ХХК-ийн захирал   |

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:

- |                           |  |
|---------------------------|--|
| 1.Гэлэнхүүгийн Батжаргал  | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан                     |
| 2. Чойсүрэнгийн Гэрэлтуяа | “Артгэрэл” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн |
| 3. Содовын Эрдэнэцэцэг    | “Мон-Энержи” Консалт ХХК-ийн Зураг төслийн газрын дарга              |
| 4. Баасанжавын Чанцалмаа  | “Очиртааб” ХХК-ийн захирал, Монголын Архитекторуудын эвлэлийн гишүүн |

“ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:

- |                      |  |
|----------------------|--|
| 1.Намхайн Эрдэмбэлэг | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан |
|----------------------|--|

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Худалдан авах ажиллаганы ил тод  
байдлыг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус дүүрэгт нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, ажлын явцын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, тайлагнах арга хэмжээг тогтмол авч ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



БАТЦЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нийтлэг журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан журмыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад сурталчилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нийтлэг журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нийтлэг журмын зорилго нь дүүргийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрхлэж буй “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа, оршин сууж буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавихад оршино.

1.2. “Нийтийн байр” гэдэгт 5 ба түүнээс дээш өрөөнд түр болон урт хугацааны түрээсийн гэрээгээр иргэнд ашиглуулж буй барилгыг хамааруулна.

1.3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод журам, түрээсийн гэрээ байгуулсан байна.

1.4. Энэхүү журмыг Нийтийн байрны үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.

1.5. Дүүргийн Худалдаа үйлчилгээний зөвлөлөөс бүртгэж, зөвшөөрөл олгоно.

Хоёр. Нийтийн байрны үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, үүрэг

2.1. “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа эрхлэгчид нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлж ажиллана.

2.2. Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зааварчилга, зөвлөгөө авах эрхтэй.

2.3. Бусдын хууль ёсны ашиг сонирхол, алдар хүнд, нэр төрийг хохироохгүй, нийгмийн дэг журмыг гажуудуулахгүй байх, гэмт хэргийн халдлагаас өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хуулийн хүрээнд хамгаалах, өөрөө үлгэр жишээ үзүүлж оролцохын дээр бусдыг шаардаж ажиллах эрхтэй.

2.4. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байх

2.5. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хүчин төгөлдөр норм, дүрмийг баримталж, хэм хэмжээ, стандартыг хангаж ажиллах

2.6. Нийтийн байрны барилгын цахилгааны дотуур угсралтанд ачааллын хэмжилтийг Эрчим хүчний мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргуулах

2.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар мэргэжлийн байгууллагын болон бусад эрх бүхий албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэн, аливаа саад учруулахгүй хамтарч ажиллах

2.8. Архидан согтууралт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

2.9. “Хог хаягдлын тухай” хуулийн заалтыг дагаж мөрдөх, хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөрөө аж ахуйн нэгж байгууллагын үнэлгээгээр төлөх

2.10. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн орчныг хариуцсан газраа тогтмол цэвэр байлгаж, хог хаягдлаа ил асгахгүй, салхинд хийсгэж тараахгүй байхаар зохицуулж, мод, бут, сөөг, зүлэг тарьж ургуулах, хамгаалах, цас мөсийг цэвэрлэж, хальтиргаа гулгаа үүсгэхгүй байх, хаяг, гэрэлтүүлэг, чимэглэлийн холбогдох байгууллагаас батлагдсан зааврын дагуу үзэмжтэй хийлгэх, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж гэмтээхгүй байх

2.11. Нийтийн байрны үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүд газар эзэмших эрхийн гэрчилгээтэй, мэдээллийн санд кадастрын зураг нь бүртгэгдсэн байх, Нийтийн байр түрээслэн үйл ажиллагаа явуулсан бол газрын төлбөр төлөх

2.12. Камерын хяналт нь дүүргээс тухайн нутаг дэвсгэрт суурилуулсан камерын сүлжээтэй хамт нэгдсэн хяналтанд авагдах боломж бололцоог хангасан байх

2.13. Нийтийн байранд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг, зурагт хуудас байрлуулж, яаралтай тохиолдолд холбогдох утасны дугааруудыг байрлуулсан байх

2.14. “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа эрхлэгчид даатгалд бүрэн хамрагдсан байна.

Гурав. Нийтийн байранд оршин суугчдын нийтлэг эрх, үүрэг

3.1. Нийтийн байранд оршин суугч нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, эрүүл тохилог орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэхийг шаардах эрхтэй.

3.2. Гудамж талбай олон нийтийн газарт хэрүүл, зодоон үүсгэх, бусдыг, айлган сүрдүүлэх, архидан согтуурч агсан тавих, ил задгай бие засах, нус цэрээ хаях зэргээр орчныг бохирдуулж олон нийтийг үл хүндэтгэсэн үйлдэл гаргах, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж танхайрахгүй байх

3.3. Иргэний үнэмлэх болон иргэний гэр бүлийн бичиг баримтын шилжилт, хөдөлгөөнийг 72 цагийн дотор холбогдох журмын дагуу хийлгэж, дээрх бичиг баримтыг эзэмших талаар гарсан журмыг чанд сахин биелүүлэх

3.4. Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох талаар бусдаас шаардах, шуурхай мэдээллэх, нуун дарагдуулахгүй байх, цагдаа, хуулийн байгууллагатай нягт хамтран ажиллаж, энэ чиглэлээр туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлэх

Дөрөв. Энэхүү журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

4.1. Энэхүү журмыг зөрчигчдөд Монгол Улсын шүүх, тухайн шатны Засаг дарга, Цагдаагийн ажилтан, тусгайлан эрх олгогдсон улсын байцаагч болон тухайн байгууллагын дээд шатны эрх бүхий албан тушаалтнууд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулинд заасан захиргааны шийтгэл ногдуулна.

4.2. “Нийтийн байр”-ны үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага энэхүү журмыг удаа дараа зөрчвөл дүүргийн Худалдаа үйлчилгээний зөвлөлөөс олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.

Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү журам нь дүүргийн нутаг дэвсгэрт 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Дүүргийн газар зохион байгуулалтын  
2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөний биелэлтийг ханган, холбогдох хэлтэс албадын уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Хэрэгжилтийн үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

**Агаарын бохирдлыг бууруулах  
ажлыг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт агаар, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн агаарын чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлэн ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Хэрэгжилтийн үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

“Ногоон дүүрэг” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн байгаль орчин, ногоон хөгжлийн талаар баримтлах “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар, хөрсний бохирдлыг багасгах, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, иргэд, олон нийтийн байгаль хамгаалах дадал, бүх нийтийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжин тодорхой ажлуудыг жил бүр төлөвлөн үе шаттайгаар зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



ДВАТ-ЭРДЭНЭ



“Ногоон дүүрэг” хөтөлбөр

Нэг. Хөтөлбөрийн зорилго, үндэслэл

1.1. Хот суурингийн ус, хөрс, агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгахад төр, засгийн оновчтой шийдвэр, шуурхай зохицуулалт, иргэдийн ухамсартай, ухаалаг зөв хэрэглээ шийдвэрлэх үүрэгтэй.

1.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар, хөрсний бохирдолыг багасгах, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар иргэд, олон нийтийн байгаль хамгаалах дадал, ухамсарт бүх нийтийн экологийн боловсрол төлөвшүүлэх, Чингэлтэй хайрхан уулын дээд салхитын амыг Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулснаар ойжуулалтыг хийх, Улаанбаатар хотын 2030 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

1.3. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурласан тохижилтын зөв бодлого, менежментэд түшиглэсэн хот, нийтийн тохижилт, бүтээн байгуулалтын зорилт, төлөвлөлтийн хүрээнд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналт нь нэн тэргүүний зорилт байх ёстой.

Хоёр. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан Ажлын хэсэг зохион байгуулж Монгол Улсын Засгийн газрын бодлого, хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах үүрэг хүлээнэ.

2.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зохицуулалтыг хийх, тайлан мэдээ, мэдээллийг боловсруулж дүгнэх, сургалт судалгааны ажлыг зохион байгуулах, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Ажлын хэсэг хариуцан гүйцэтгэнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиглэл

3.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ургамлан болон орчин үеийн шийдэл бүхий хашлага бий болгож тэдгээрийн арчилж хамгаалахад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэж буй иргэд, аж ахуй нэгжийг сурталчилгааны бодлого, нийгмийн хариуцлатай нь уялдуулж татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

3.2. Дүүргийн нутаг дэвсгэр дэх орон сууцны хороолол дундах бичил цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгааг тухайн орчны сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай хамтран ажиллах гэрээгээр уялдуулж, мэргэжлийн

байгууллагын оролцоотой сургалтанд хамруулж, үнэлгээг тогтмол хийж хэвшүүлнэ.

3.3. Төрийн зарим чиг үүргийн дагуу байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүд өөрсдийн санал санаачилга, оролцоонд тулгуурласан байгаль хамгаалах төслүүдийг дэмжиж ажиллана.

3.4. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус сургууль, цэцэрлэгийн гадна талбайн батлагдсан “Дендроплан” ажлын зургийн дагуу үе шаттайгаар тарилт хийнэ.

3.5. Байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж, ургуулсан мод буцыг урамшуулах, тогтолцоог бий болгох, мод буцыг ургалтын чанараас нь хамаарч Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайд, Сангийн Сайдын хамтарсан 2013 оны А-96 /71 тоот тушаалыг үндэслэн худалдан авна.

3.6. Чингэлтэй хайрхан ууланд ойжуулалт, нөхөн сэргээлт хийхэд иргэд, аж ахуй нэгжийг татан оролцуулах замаар жилд 5000-аас доошгүй модоор ойн санг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

4.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дор дурдсан эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Төвлөрсөн болон орон нутгийн төсөв
- Байгаль хамгаалах сан
- Олон улсын байгууллага, хандивлагчдаас өгч буй тусламж, дэмжлэг, хандив
- Төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж

Тав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

5.1. Хөтөлбөр 2 үе шаттайгаар 2014 оноос 2016 оны хооронд хэрэгжинэ.

- 1-р үе 2014-2015 он
- 2-р үе 2015-2016 он

Зургаа. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг бүтэн жилээр, Ажлын хэсэг үнэлнэ.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт.

| № | Шалгуур үзүүлэлт                                     | 2014 он  | 2015 он                          | 2016 он | Эх үүсвэр |
|---|--|--|----------------------------------|---------|-----------|
| 1 | Ногоон байгууламжийн м <sup>2</sup> нэмэгдсэн байдал | Дүүргийн хэмжээнд 10000 м <sup>2</sup> -аас доошгүйгээр нэмэгдүүлнэ. | 10000 м <sup>2</sup> нэмэгдүүлнэ | 10,000  |           |

|   |   |   |  |  |  |
|---|---|---|--|--|--|
| 2 | Дүүргийн хэмжээнд таригдсан модны тоо   | Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, сургууль, цэцэрлэг, иргэд аж ахуй байгууллагийн хашаанд таригдан.<br>Үүнд:<br>Шилмүүст мод-4000<br>Навчит мод-6000<br>Ургамлын хашилага-30000 | Шилмүүст болон Навчит мод 10000<br>Ургамлын хашилага-30000 | Шилмүүст болон Навчит мод 10000<br>Ургамлын хашилага-30000 |  |
| 3 | Байгаль орчин, ногоон байгууламжийн чиглэлээр хийгдсэн сургалт сурталчилгаа, хамрагдсан хүний тоо | 105 хүн ногоон байгууламжийн чиглэлээр сургалт семинарт хамрагдсан.   | 120 дээш хүн хамруулна                                     | 120 дээш хүн хамруулна                                     |  |
| 4 | Чингэлтэй хайрхан ууланд ойжуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийж, таригдсан модны тоо                 | 5000 доошгүй шилмүүст болон навчит модоор ойжуулалт хийнэ.  | 5000 доошгүй шилмүүст болон навчит модоор ойжуулалт хийнэ. | 5000 доошгүй шилмүүст болон навчит модоор ойжуулалт хийнэ. |  |
| 5 | Ногоон байгууламжийн тарилт арчилгааны ажлыг зохион байгуулах                                     | IY/15- нээлт  | IY/15- нээлт   | IY/15- нээлт   |  |
|   |   | X/15- хаалт   | X/15- хаалт  | X/15- хаалт  |  |

Найм. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн:

8.1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчны нэгдсэн төлөвлөлттэй, нийтийн эзэмшлийн зүлэгт талбай жилд 10000 м<sup>2</sup>-аас доошгүйгээр нэмэгдэж, ногоон байгууламжийн хамгаалалтын ургамлан болон орчин үеийн шийдэл бүхий хашлага 1500-аас доошгүйгээр хийнэ.

8.2. Сурагчдын эрүүл, таатай орчинд суралцах нөхцлийг сайжруулна.

8.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэгийн ногоон байгууламж тарьж ургуулах, түүний арчилгаа, хамгаалалтад иргэд, аж

ахуй нэгжийн оролцоо нэмэгдсэнээр навчит болон шилмүүст 8000-аас доошгүй мод, 30000-аас доошгүй ургамлан хашлага бүхий ногоон байгууламж бий болгож ургалтын чанарыг 75 хувиас дээш ургуулах.

8.3. Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэд, бүлгийн санал санаачлага, оролцоонд тулгуурлан холбогдох төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажилласнаар навчит болон шилмүүст 5000-аас доошгүй мод Чингэлтэй хайрхан уулын ойн сан нэмэгдэнэ. Мод, бутны арчилгаа, хамгаалалт, нөхөн тарилтыг горимын дагуу зохион байгуулж, ургалтын чанарыг 80 хувиас дээш ургуулна.